

1. Сонсоод монгол ардын дуу хөгжмийн ямар төрөлд хамаарахыг сонгоорой.

- A. өгүүлэх эрхтний шүтэлцэх урлаг
- B. хөгжимт аман зохиол
- C. монгол ардын дуулах урлаг
- D. монгол ардын хөгжимдөх урлаг

2. Сонссон бүтээл нь хөөмийн урлагийн ямар төрөл вэ?

- A. хөөмийн шахаа
- B. хөөмийн хархираа
- C. хөөмийн исгэрээ
- D. хөөмийн нармай

3. Утга агуулгаараа монгол орны үзэсгэлэнт байгаль, ан гөрөөс, араатан жигүүртэн, хүн ардад буян хишгээ хайрладаг талаар магтан дуулах хэлбэрийг хөгжимт аман зохиолын.....төрөл гэж нэрлэнэ.

- A. хүндэтгэл магтаал
- B. хангайн магтаал
- C. туульс магтаал
- D. алтайн магтаал

4. Монгол ардын дууг ерөнхийд ньбагэж хуваан үздэг.

- A. уртын, богинын
- B. бүүвэйн дуу, хөдөлмөрийн дуу
- C. дайралцаа, ёс заншлын
- D. хүрээ дуу, харилцаа дуу

5. Монгол ардын уртын дууны онцлог юу вэ? Зөв хувилбарыг сонгоно уу.

- A. Сэтгэлгээний хувьд гүнзгий утга агуулгыг илэрхийлсэн, түүнэчлэн шуранхай, шигшлэг, цохилго зэрэг аялгууны чимэглэл ихтэй тул дуучнаас үр чадвар ихээхэн шаарддаг.
- B. Аялгууны чимэглэл ихтэй. Дуучнаас үр чадвар бага шаарддаг учраас хүн бүхэн сурч дуулах боломжтой.
- C. Аялгууны цараа багатай. Дуучнаас үр чадвар их шаарддаг учраас хүн бүхэн сурч дуулах боломжгүй.
- D. Аялгууны үсрэлт ихтэй, хөг шилжилт элбэг тохиолддог тул дуулахад хялбар.

6. Монгол ардын уртын дууг бүтцээр нь хэрхэн ангилдаг вэ?

- A. айзам, суман, бэсрэг
- B. суман, бэсрэг, айзам, төв халх
- C. төв халх, боржгон, баян бараат, зүүн аймгийн
- D. айзам, суман, баян бараат

7. Чавхдаст нумт хөгжмийн зэмсгийн төрөлд ямар ямар хөгжмийн зэмсгүүд багтдаг вэ?

- A. морин хуур, их хуур, хуучир
- B. хуучир, их хуур, босоо ятга
- C. их хуур, морин хуур, шанз
- D. морин хуур, их хуур, шанз

8. Зургийг ажиглаад хөгжмийн зэмсгийн нэрийг сонгоно уу.



- A. ятга B. ёочин C. шанз D. босоо ятга

9. Хөгжмийн зэмсэг нь тоглох арга барилын хувьд ямар төрөлд хамаарах вэ?

- A. чавхдаст товшвор хөгжим B. чавхдаст цохивор хөгжим
C. үлээвэр хөгжим D. чавхдаст нумт хөгжим

10. Баруун Монголчуудын дунд өргөн тархсан бүжгийн урлагийн төрөл аль нь вэ?

- A. бий биелгээ B. ардын бүжиг
C. зохиомжит бүжиг D. орчин үеийн бүжиг

11. Язгуур бий биелгээний дараах “Гарын байрлал”-уудаас дээдлэх гар аль нь болохыг сонгоно уу?



12. Язгуур бий биелгээний үндсэн зогсолтуудыг нэрлэж бичнэ үү?

